



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар A/134

Баян-Овоо

**Орон нутгийн хөгжлийн сангаас зардал
гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 22 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, хичээлийн А байрны их засвар хийх” ажлын явцын санхүүжилт болох 41.768.686 (Дөчин нэгэн сая долоон зуун жаран найман мянга зургаан зуун наян зургаан) төгрөгийн зардал гаргасугай.

2.ХЭАДСЗДТГ/2024-02 дугаартай гэрээний дагуу 41.768.686 (Дөчин нэгэн сая долоон зуун жаран найман мянга зургаан зуун наян зургаан) төгрөгийг “ЮУ ЗЭТ ЭРДЭНЭ” ХХК-ны ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН банкны 423002777 тоот дансанд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн данснаас шилжүүлэхийг Сангийн нягтлан бодогч (Д.Даваадорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХ-ОД

010000237